

**АЙМАГ,НИЙСЛЭЛИЙН ЭМГ, БОЭТ, ТӨРӨЛЖСӨН
НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛЭГ, ТӨВИЙН
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ**

Зэргийн шалгалтын материал ирүүлэх тухай

Тус мэргэжлийн салбар зөвлөл нь 2013 оны мэргэжлийн зэргийн шалгалт авах болсонтой холбогдуулан шалгалт өгөх эмийн шинжээч, эмийн технологч, эм зүйн албаны менежер-зах зээл судлаач болон эм найруулагч нарын материалыг 3-р сарын 01-ны дотор ЭМШУИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйн албаны зохион байгуулалт технологийн тэнхим /Сувилахуйн сургууль/ 103 тоот өрөөнд ирүүлнэ үү.

Бүрдүүлэх материал болон тусгай шалгуурыг хавсаргав./Хавсралт1,2/

Харилцах утас:99862067

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Цэрэнлхагва

Хамтран ажилласанд баярлалаа.

Эм судлал, эм зүйн мэргэжлийн салбар

Зөвлөлийн дарга, төрийн шагналт,

Эм зүйн ухааны доктор, профессор

Л.Хүрэлбаатар

Хавсралт 1

Бүрдүүлэх материал:

- 1.Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
- 2.Байгууллагын даргаар баталгаажуулсан мэргэжлийн зэрэг горилогчийн бүрэн бөглөсөн маягт. /Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулсан загвараар/
- 3.Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэх /эх хувь/
- 4.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажсан хувь/
- 5.Мэргэжил дээшлүүлсэн үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажсан хувь/
- 6.Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
- 7.Байгууллагын тодорхойлолтонд бүтээлийн хуулбар /илтгэл, судалгаа, хэвлүүлсэн материал/-ыг хавсарган байгууллагын даргаар баталгаажуулсан байна.
- 8.3x4 хэмжээний фото зураг 2 хувь

Мэргэжлийн зэргийн шалгалтын зохион байгуулалт

Хугацаа:2013 оны шалгалтыг 5-р сарын 1-наас 5-р сарын 25-ний хооронд ЭМШУИС-ийн Эм зүйн сургуулийн байранд зохион байгуулна.

Зэргийн шалгалтанд орох болзол хангасан эм зүйч, эм найруулагчдын материалыг 3-р сарын 01-ний дотор ЭМШУИС-ийн Эм зүйн сургуулийн Эм зүйн албаны зохион байгуулалт, технологийн тэнхим /Сувилахуйн сургууль/103 тоот өрөөнд нарийн бичгийн дарга Р.Цэрэнлхагвад /утас 99862067/ хүлээлгэн өгнө.

Мэргэжлийн зэргийн шалгалт

- 1.Мэргэжлийн шалгалт нь мэргэжлийн болон эрх зүйн чиглэлтэй байна.
- 2.Мэргэжлийн шалгалтыг онол болон дадлагаар авах бөгөөд онолын шалгалтанд 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд дадлагын шалгалтанд орно.
- 3.Онолын шалгалтыг сорилоор, дадлагын шалгалтыг гардан үйлдэл, практик бодлого, ярилцлагын хэлбэрээр авна. Онолын шалгалтын 20 хувь нь хууль эрх зүй, ёс зүйн асуулт байна.
- 4.Онолын шалгалтын дүнг шалгалт дууссанаас хойш 1 цагийн дотор шалгагч машинаар дүгнэн, дадлага шалгалтын дүнг шалгалтын дараа шууд мэдээнэ.
- 5.Шалгалтын дүнгийн бодит байдлыг шалгалтын комисс хариуцна.
- 6.Зэрэг горилогч нь мэргэжлийн онолын болон дадлагын шалгалтанд тус бүр 85-аас дээш үнэлэгдсэн нөхцөлд тэнцсэнд тооцно.

Төлбөр:Зэргийн шалгалтын төлбөрийг шалгалт эхлэхээс 1 сарын өмнө зарласан дансанд тушаасан байна.
Данс:МЭЗБН “Эм” Холбоо Голомт банк 1102099478 тоот данс

- 1.Эм зүйч ахлах, тэргүүлэх, зөвлөх-125000 төгрөг
- 2.Эм найруулагч ахлах зэрэг-65000 төгрөг

Шалгалт авах хугацаа :

- Эм зүйчдээс авах ахлах, тэргүүлэх, зөвлөх, эм найруулагчдаас авах ахлах зэргийн шалгалт:
- мэргэжлийн болон эрх зүйн чиглэлээр 5-р сарын 6..... -нд
- Эм найруулагчдын ахлах зэргийн дадлагын шалгалтыг 5-р сарын -нд
- Эм зүйчдийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн дадлагын шалгалтыг 5-р сарын -нд тус тус авна.

Нэг.Ерөнхий зүйл

“Эм зүйн мэргэжилтнүүдэд мэргэжлийн зэрэг олгох журам”-ыг боловсруулахдаа Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011оны 12-р сарын 08-ний өдрийн 408/500 тоот хамтарсан тушаалыг үндэслэн “Эм” холбооны дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Энэхүү журмын зорилго нь эм зүйч, эм найруулагч нарт мэргэжлийн зэрэг олгох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Ажил үйлчилгээний мэргэжлийн болон чанарын шаардлагыг бүрэн ханган ажилласныг тухайн байгууллагын удирдлага үнэлж, хамт олон нь дэмжсэн нөхцөлд эм зүйн мэргэжилтэн өөрийн хүсэлтээр мэргэжлийн зэрэг горилоно.

Мэргэжилтэнд ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийг шат дараалан тухайн эм зүйн мэргэжилтэнд нэг удаа олгоно.

Хоёр.Мэргэжлийн зэрэг горилогчид тавигдах ерөнхий шаардлага

2.1.Ахлах зэрэг горилох эм зүйч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- 2.1.1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх
- 2.1.2.Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх
- 2.1.3.Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх
- 2.1.4.Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

2.1.5.Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, үр дүнгээс нь 2-оос доошгүй судалгааны ажлыг нийтлүүлсэн байх.

-Эмийн шинжээчээр ахлах зэрэг горилогч нь эм зүйн ухааны асуудлаар санал дүгнэлт гаргах, сургалт явуулах, эмийн сан, эмийн чанарын лабораториудад эмийн шинжилгээний мэргэжлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх

-Эмийн технологчоор ахлах зэрэг горилогч нь эм зүйн ухааны асуудлаар санал дүгнэлт гаргах, сургалт явуулах, эмийн сан, эмийн үйлдвэрт бэлтгэгдэж буй эмийн чанарыг хянахад эмийн технологийн мэргэжлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх

-Эм зүйн албаны менежер-зах зээл судлаачийн ахлах зэрэг горилогч нь эм зүйн албаны менежмент, эмийн зах зээл судлалын онолын үндэслэл, эмийн үндэсний бодлого, хууль тогтоомжийн асуудлаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн, эм хангамжийн байгууллагуудын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг үр ашигтай хөтлөн явуулах мэргэжлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх

2.2.Тэргүүлэх зэрэг горилогч эм зүйч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

2.2.1.Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх.

2.2.2.Тухайн мэргэжлээрээ ахлах зэрэг авсанаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

2.2.3.Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх

2.2.4.Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

2.2.5.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гардан хийж, сүүлийн 5 жилд 3-аас доошгүй бүтээл хэвлүүлж олны хүртээл болгосон байх

-Эмийн шинжээчээр тэргүүлэх зэрэг горилогч нь эм зүйн ухааны асуудлаар бусадтай хамтран зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах, сургалт явуулах эмийн сан, эмийн чанарын лабораториудад нарийн мэргэшлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх.

-Эмийн технологчоор тэргүүлэх зэрэг горилогч нь эм зүйн ухааны асуудлаар бусадтай хамтран зөвлөлгөө өгөх, санал дүгнэлт гаргах, сургалт явуулах, эмийн сан, эмийн үйлдвэрт бэлтгэгдэж буй эмийн чанарыг хянахад нарийн мэргэшлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх.

-Эм зүйн албаны менежер-зах зээл судлаачийн тэргүүлэх зэрэг горилогч нь удирдлагын шинжлэх ухаан, эм зүйн албаны менежмент, эмийн зах зээл судлалын онолын үндэслэл, эмийн үндэсний бодлого, хууль тогтоомжийн асуудлаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн, чөлөөт зах зээлийн харилцаны нөхцөлд эм зүйн байгууллагуудын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан явуулахад нарийн мэргэшлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх.

2.3.Зөвлөх зэрэг горилогч эм зүйч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

2.3.1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх

2.3.2.Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх

2.3.3.Боловсролын докторын зэрэгтэй байх

2.3.4.Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй

2.3.5.Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

2.3.6.Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн байх

2.3.7.Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гардан хийж, 5-аас доошгүй бүтээл хэвлүүлж, үүний 3-ыг олон улсын хуралд илтгэсэн, мэргэжлийн хэвлэлд нийтлүүлсэн байх.

-Эмийн шинжээчээр зөвлөх зэрэг горилогч нь эм зүй, эм судлалын асуудлаар бие даан зөвлөлгөө өгөх,

дүгнэлт гаргах, сургалт явуулах, эрдэм шинжилгээний ажил бие даан хийх, эм хангамжийн болон урьдчилан сэргийлэх байгууллагад эмийн холбогдолтой асуудлаар өндөр түвшингийн мэргэжлийн тусламжийг үзүүлэх чадвартай байх

-Эмийн технологчоор зөвлөх зэрэг горилогч нь эм зүй, биофармацын шинжлэх ухааны асуудлаар бие даан зөвлөлгөө өгөх, дүгнэлт гаргах, сургалт явуулах, эрдэм шинжилгээний ажил бие даан хийх, эмийн сан, эмийн үйлдвэр, эмчилгээ урьдчилан сэргийлэх байгууллага болон хэрэглэгчдэд эмийн чанарын баталгаа, эмийн зохистой хэрэглээний талаар болон эмтэй холбоотой аливаа асуудлаар өндөр түвшинд мэргэжлийн тусламж үзүүлэх чадвартай байх.

-Эм зүйн албаны менежер-зах зээл судлаачийн зөвлөх зэрэг горилогч нь удирдлагын шинжлэх ухааны арга барилын үндсэн элементүүдийг эм зүйн байгууллагуудын удирдлагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн байх, энэхүү мэргэжлээрээ бие даан зөвлөлгөө өгөх, мэргэжлийн санал, үнэлэлт дүгнэлт өгөх хэмжээнд бэлтгэгдсэн, сургалт явуулах, эрдэм шинжилгээний ажил бие даан хийх, чөлөөт зах зээлийн харилцааны нөхцөлд эмийн үйлдвэрлэл, дотоод гадаад худалдаа, хангамж борлуулалт, нийлүүлэлт үйлчилгээ эрхэлдэг бие даасан аж ахуйн нэгж томоохон байгууллагуудын үйл ажиллагааг зах зээл судлалын ухааны үүднээс иж бүрдлээр хөтлөн явуулах өндөр түвшинд мэргэжлийн тусламж үзүүлэх чадвартай байх

2.4.Ахлах зэрэг горилох эм найруулагч дараах шалгуурыг хахгасан байна. Үүнд:

2.4.1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх

2.4.2.Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх

2.4.3.Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх

2.4.4.Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

2.5.Тэргүүлэх зэрэг горилох эм найруулагч дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

2.5.1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх

2.5.2.Тухайн мэргэжлээрээ ахлах зэрэг авсанаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх

2.5.3.Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх

2.5.4.Шинэлэг арга технологи, дадлага эзэмшиж үр дүнд хүрсэн байх.

-Эм найруулагчаар тэргүүлэх зэрэг горилогч нь эмийн үндэсний бодлого, хууль тогтоомжийн асуудлаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн, эм зүйн байгууллагуудын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан явуулахад нарийн мэргэшлийн тусламжийг гардан хийж гүйцэтгэх чадвартай байх